# БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
# ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 10 өдөр Дугаар А/197 Булган

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, аймгийн ИТХ-ын X хуралдааны 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 10/07 дугаар тогтоолын тавдугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээнд тусгагдсан “Ойн хортны судалгааны ажлыг гүйцэтгэх” гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дугаартай зөвлөмжийн дагуу Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага төрийн бус байгууллагатай 16 955 500 /арван зургаан сая есөн зуун тавин таван мянга таван зуу/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай
2. Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага төрийн бус байгууллагын ажлын гүйцэтгэлд холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.
3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг Байгаль орчин, тогтвортой хөгжлийн санаачлага төрийн бус байгууллага /Ж.Жаргал/-д үүрэг болгосугай.
4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА З.БАТЗОРИГ

Б ЗДТГ ХОХБТХ Захирамж

20190199